



БОЛОВСРОЛЫН ЯАМ

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ



PISA

УНШИХ ЧАДВАРЫН БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

СУРЛАГЫН АМЖИЛТЫН ОЛОН УЛСЫН ҮНЭЛГЭЭ

УЛААНБААТАР ХОТ-2024

PROGRAMME FOR INTERNATIONAL STUDENT ASSESSMENT

БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Рапа нуи1/1

Танин мэдэхүйн үйл явц	Текст доторх мэдээлэлд хандах, авах
Даалгаврын төрөл	Энгийн олон сонголтод
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Нэг
Хүндрэлийн түвшин	559 – Түвшин 4

- **Бүтэн оноо:** В. 9 сарын өмнө
Оноогүй: Бусад хариултууд

➤ Тайлбар

“Профессорын блог” бичвэрт байгаа цаг хугацаатай холбоотой нийтэлсэн огноо, моайгийн анхны нууцыг тайлсан цаг хугацаа (1990-ээд он) зэргээс зөв мэдээллийг олж сонгох нь чухал юм.

Рапа нуи1/2

Танин мэдэхүйн үйл явц	Шууд утгыг илэрхийлнэ
Даалгаврын төрөл	Нээлттэй хариулт
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Нэг
Хүндрэлийн түвшин	513 – Түвшин 3

- **Бүтэн оноо:** Хариултууд нь хөшөөг (моаи) хөдөлгөхөд ашигласан материал алга болсныг илэрхийлнэ.

- Моайг хөдөлгөж байсан эдгээр ургамал, том мод юу яасан бэ? [Шууд ишлэл]
- Моайг хөдөлгөж чадах том мод байхгүй.
- Тэнд өвс, бут сөөг, зарим жижиг мод байдаг боловч том хөшөөг хөдөлгөх хэмжээний мод байхгүй.
- Том моднууд хаана байна вэ? [Хамгийн багаар]
- Ургамал хаана байна вэ? [Хамгийн багаар]
- Хөшөөг тээвэрлэхэд шаардлагатай нөөцтэй юу болсон бэ?
- Тэр эргэн тойрноо хархад ямар ч том мод, ургамал байгаагүй тул моайг хөдөлгөсөн зүйлийг тэр хэлэх гэсэн байгаа. Тэр мөн тэдэндэй юу тохиолдсон бэ гэдэгт гайхдаг. [Хэдийгээр энэ хариулт буруу нууцыг иш татсанаас эхэлсэн ч зөв элементүүдийг агуулж байгаа.]

Оноогүй: Бусад хариултууд

➤ Тайлбар

Энэ асуултад хариулахын тулд блогт дурдсан хоёр дахь нууц буюу нэгэн цагт Рапа Нуид ургаж, моайг хөдөлгөж байсан том мод юу болсон бэ гэдгийг ойлгох ёстой болно. Хариулахдаа блогтоос шууд эшлэл (Эдгээр ургамлууд болон моайг хөдөлгөхөд ашигласан том мод юу болсон бэ?) эсвэл үнэн зөв тайлбарыг өгч болно.

Рапа нуи1/3

Танин мэдэхүйн үйл явц	Агуулга, хэлбэрийн талаар эргэцүүлэн бодох
Даалгаврын төрөл	Цогцолбор олон сонголтод
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Нэг
Хүндрэлийн түвшин	654 - түвшин 5

- **Тайлбар**
Эхлээд өгүүлэмж бүрийн шууд утгыг ойлгох ёстой бөгөөд дараа нь агуулга нь бодитой эсэх эсвэл зохиогчийн хэтийн төлөвийг илэрхийлсэн эсэхийг шийдэх ёстой. Ийм маягаар сурагч зөвхөн утга санаанаас илүү агуулга, түүнийг хэрхэн танилцуулж байгаад анхаарлаа хандуулах ёстой.

- **Бүтэн оноо:** Анхаар бүгдийг зөв хийсэн тохиолдолд л өгнө.

Зөв хариу: Баримт, Үзэл бодол, Баримт, Баримт, Үзэл бодол.

Оноогүй: Бусад хариултууд

Рапа нуи 1/4

Танин мэдэхүйн үйл явц	Текст доторх мэдээлэлд хандах, авах
Даалгаврын төрөл	Энгийн олон сонголтод
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Нэг
Хүндрэлийн түвшин	634 – түвшин 5

- Бүтэн оноо: В. Рапа Нуигаас том мод алга болсон.

Оноогүй: Бусад хариултууд

- Тайлбар
Зөв хариултыг олохын тулд эрдэмтэд болон Жаред Даймонд (2-р бадаг)-оос ишлэлтэй хэсгийг олж, тохирсон мэдээллийг агуулсан өгүүлбэрийг тодорхойлох шаардлагатай. Энэ даалгавар нь олон эх сурвалжийн хэрэглээг тусгасан танин мэдэхүйн үйл явцаар ангилагдаагүй болно. Даалгаврын хүндрэл нь хүний суурьшилтай холбоотой хэсэгт анхаарал сарниулах үнэмшилтэй (гэхдээ буруу) мэдээлэл байгаад оршиж байна..

Рапа нуи 1/5

Танин мэдэхүйн үйл явц	Зөрчилдөөнийг илрүүлж, зохицуулах
Даалгаврын төрөл	Энгийн олон сонголтод
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Олон
Хүндрэлийн түвшин	597 – Түвшин 4

- Бүтэн оноо: D. Дал модны самрын үлдэгдэлд харх хазаж мэрсний ул мөр үлдсэн байна.

Оноогүй: Бусад хариултууд

- Тайлбар
Бичвэр дэх ямар мэдээлэл нь эрдэмтдийн дэвшүүлсэн онолыг дэмжиж, баталж байгааг ойлгох нь чухал юм. Бичвэрээс аль өгүүлэмжийг батлах, нотлох баримт болгон ашиглаж болохыг тодорхойлох ёстой. Танин мэдэхүйн үйл явц нь зөрчилдөөнийг илрүүлэх, зохицуулах гэж тодорхойлогдсон бүх даалгавар нь хоёр эх сурвалжийн хоорондох зөрчилдөөнийг илрүүлэх эсвэл хоёр буюу түүнээс дээш эх сурвалжийн мэдээлэл баталгаажсан болохыг хүлээн зөвшөөрөх зэрэг чадварыг шаардаж байна.

Рапа нуи 1/6

Танин мэдэхүйн үйл явц	Олон эх сурвалжийг нэгтгэж, дүгнэлт гаргах
Даалгаврын төрөл	Багц олон сонголтод
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Олон
Хүндрэлийн түвшин	665 – Түвшин 5

- **Бүтэн оноо:** Анхаар бүгдийг зөв хийсэн тохиолдолд л өгнө.
 - Зөв хариу: Шалтгаан - Хүмүүс газар тариалан болон бусад шалтгаанаар газар чөлөөлөхийн тулд мод тайрсан. Шалтгаан - Полинезийн хархнууд модны үрийг идэж, үр дүнд нь шинэ мод ургах боломжгүй болсон. Нөлөө (ерөнхий) – Том моднууд Рапа Нуигаас алга болсон.

Оноогүй: Бусад хариултууд

- Тайлбар
Жаред Даймонд, нөгөө талаас Карл Липо, Терри Хант нарын дэвшүүлсэн ялгаатай онолуудын талаарх мэдээллийг нэгтгэх нь чухал юм. Суралцагч моайг хаана сийлсэн тухай (нэг карьерт)

блогт оруулсан мэдээллээс татгалзаж, ерөнхий үр нөлөөг (том мод алга болсон) тодорхойлох ёстой. Цаашилбал, эрдэмтэн судлаач бүр алга болсон шалтгааныг юу гэж үзэж байгааг ойлгох хэрэгтэй.

Рапа нуи 1/7

Танин мэдэхүйн үйл явц	Зөрчилдөөнийг илрүүлж, зохицуулах
Даалгааврын төрөл	Нээлттэй хариулт
Даалгааврын эх сурвалжийн шаардлага	Олон
Хүндрэлийн түвшин	588 – Түвшин 4

- **Бүтэн оноо:** Дараах нь нэг буюу хэд хэдэн тайлбаруудыг агуулна.
 1. Хүмүүс модыг тайрсан эсвэл ашигласан (моайг нүүлгэх ба/эсвэл газар тариалангийн зориулалтаар газрыг чөлөөлсөн).
 2. Хархнууд модны үрийг идсэн (шинэ мод ургах боломжгүй болсон).
 3. Цаашид судалгаа хийх хүртэл том моднуудтай яг юу тохиолдсныг хэлэх боломжгүй.
 - Хүмүүс моайг хөдөлгөх гэж хэтэрхий олон мод тайрснаас болж мод алга болсон гэж бодож байна. [1]
 - Хүмүүс газар тариалангийн зориулалтаар газрыг чөлөөлсөн. [1]
 - Модыг моайг хөдөлгөхөд ашигладаг байсан. [1]
 - Хүмүүс мод тайрсан. [1]
 - Энэ нь хүмүүсийн буруу байсан, учир нь тэд моайг хөдөлгөхийг хүссэн. [1 – энэ хариулт нь мод тайрсан тухай тодорхой заагаагүй ч хүмүүс болон мод тайрах нэг шалтгаан (моайг хөдөлгөх) гэсэн утгатай учраас хүлээн зөвшөөрч болно.]
 - Хүмүүсийн буруу. Тэд байгаль орчныг сүйтгэсэн. [1 – энэ хариулт нь модыг тайрсан тухай тодорхой заагаагүй ч мод тайрсны үр дүнг нэгтгэн дүгнэх боломжтой арга юм.]
 - Хархнууд модны үрийг идэж хамгийн их хохирол учруулсан байх гэж бодож байна. [2]
 - Хархнууд үрийг нь идсэн. [2]
 - Аль нэг нь зөв гэсэн нотолгоо байхгүй тул нэмэлт мэдээлэл гарах хүртэл хүлээх хэрэгтэй. [3]
 - Аль аль нь. Хүмүүс газар тариалан эрхлэхийн тулд том модыг тайрсан, дараа нь хархнууд модны үрийг идсэн! [1 ба 2]

Оноогүй: бусад тохиолдолд

- **Тайлбар**
Энэ хэсэгт сурагч мэдээллийг нэгтгэж, аль онолыг дэмжихээ шийдэх юм. Ийм байдлаар суралцагч онолуудыг ойлгох хэрэгтэй бөгөөд тэдгээр нь хоорондоо зөрчилдөж байгаа бөгөөд бичвэрээс бататгах хариултыг олж хариулах нь чухал юм.

ГАЛАПАГОСЫН АРЛУУД

Уншигчдад:
Төслийн хувьд гэвэл бид Галапагосын байгаль хамгаалах нийгэмлэг гэсэн шинэ байгууллагын вэбсайтыг зохион бүтээхээр шийдсэн юм. Тус нийгэмлэгийн гишүүд нь Галапагосын экосистемийн ирээдүйн талаар санаа зовж буй Эквадорын эрдэмтэд, иргэд байдаг. Бид бүх хуудсыг дуусгаж амжаагүй байгаа ч таныг санал хүсэлт, хариу өгөхөд талархах болно. Хуудаснуудаа хангалттай агуулгатай байлгах үүднээс зарим асуултад та нарыг хариулахыг хүсэж байна.

Галапагос 2/1

Танин мэдэхүйн үйл явц	Холбогдох текстийг хайж олоод сонгоно
Даалгааврын төрөл	Ердийн олон сонголт
Даалгааврын эх сурвалжийн шаардлага	Олон

- **Бүтэн оноо:** (C) замаг

Оноогүй: Бусад хариултууд

- **Тайлбар**
Асуултын хариулт нь “Галапагосын арлуудын тухай» веб хуудсанд байхгүй тул сурагч хариултаа олохын тулд өөр өөр веб хуудаснаас хайж хэрэгтэй болно. Энэ хэсэг нь өөр өөр веб хуудастай ажиллахыг дэмждэг боловч холбогдох бичвэртэй гүнзгий түвшний оролцоо шаарддаггүй.

Галапагос 2/2

<i>Танин мэдэхүйн үйл явц</i>	Холбогдох текстийг хайж олоод сонгоно
<i>Даалгаврын төрөл</i>	Нээлттэй хариулт
<i>Даалгаврын эх сурвалжийн шаардлага</i>	Олон

- **Бүтэн оноо:** Пинзон арал эсвэл Пинзон Pinzón
Оноогүй: Бусад хариултауд
- **Тайлбар**
Энэ хэсэгт сурагчид асуултын хариулт хаана байгаа талаар мэдээлэл өгөөгүй тул дөрвөн веб хуудаснаас хайж, холбогдох хариултыг олох юм.

Галапагос 2/3

<i>Танин мэдэхүйн үйл явц</i>	Бичвэр доторх мэдээлэлд хандах, авах
<i>Даалгаврын төрөл</i>	Ердийн олон сонголт
<i>Даалгаврын эх сурвалжийн шаардлага</i>	Нэг

- **Бүтэн оноо:** (A) Яст мэлхийг устахаас аврахын тулд
Оноогүй: Бусад хариултауд
- **Тайлбар**
Тухайн асуултын хариултыг “Байгаль хамгаалах» веб хуудсанд байгаа гэдгийг тодорхой зааж өгсөн байгаа юм. Сурагчид “Байгаль хамгаалах” веб хуудаснаас асуултын үндсэн мэдээлэл (яст мэлхий үржүүлэх хөтөлбөр ажиллуулж байгаа) болон веб хуудасны (үржүүлгийн хөтөлбөр эхлүүлж байгаа) мэдээлэлтэй харьцуулалт хийж сонгоно.

Галапагос 2/4

<i>Танин мэдэхүйн үйл явц</i>	Нэгтгэж, дүгнэлт гаргах
<i>Даалгаврын төрөл</i>	Ердийн олон сонголт
<i>Даалгаврын эх сурвалжийн шаардлага</i>	Олон

- **Бүтэн оноо:** (D) Тэдний тоо толгойд аюул заналхийлж байна.
Оноогүй: Бусад хариултауд
- **Тайлбар**
Энэ асуултад зөв хариулахын тулд веб хуудасны мэдээлэлд илүү гүнзгий орох хэрэгтэй. Сурагч амьтдын нийтлэг байдлыг тодорхойлохдоо амьтан тус бүрийн тайлбарыг ажиглаад гурван мэдээллийг харьцуулан нэгтгэх нь чухал юм. Харьцуулсан нэгтгэлээс дүгнэлт гаргаж зөв хариултыг сонгоно.

Галапагос 2/5

Танин мэдэхүйн үйл явц	Нэгтгэж, дүгнэлт гаргах
Даалгаврын төрөл	Ердийн олон сонголт
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Нэг

- **Бүтэн оноо:** Хариуд нь нэг хөтөлбөр нь уугуул төрөл зүйлийг үржүүлэхэд чиглэгдсэн бол нөгөө хөтөлбөр нь аюулт заналтай зүйлийг устгахад чиглэгдсэн болохыг харуулсан байна.

Оноогүй: Бусад хариултууд

- **Тайлбар**
Өмнөх хэсгээс ялгаатай нь асуултын гол нь тухайн асуултын хариултыг олохын тулд аль веб хуудас руу орох ёстойг заадаг. Гэсэн хэдий ч энэ хэсэг нь өмнөх хэсэгтэй ижил төстэй зүйл бөгөөд энэ нь сурагчаас мэдээллийг нэг веб хуудсанд нэгтгэх, веб хуудсанд тодорхой заагаагүй мэдээллийг ойлгохыг шаарддаг. Тиймээс энэ нь «нэгтгэх, дүгнэлт гаргах» хэсэг юм.

Галапагос 2/6

Танин мэдэхүйн үйл явц	Агуулга, хэлбэрийн талаар эргэцүүлэн бодох
Даалгаврын төрөл	Нээлттэй хариулт
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Олон

- **Бүтэн оноо:** Нийгэм нь амьтдын болон арлын аврах хөтөлбөрийг дэмжихийн тулд хүмүүсийг өдөөхөд баримт, нарийвчилсан зүйлүүдийг ашиглаж байгааг хариултууд харуулсан байна.

Оноогүй: Бусад хариултууд

- **Тайлбар**
Энэ асуултад зөв хариулахын тулд эхлээд арлууд дээрх амьтдын тухай болон байгаль хамгаалах хөтөлбөрийн талаарх хоёр веб хуудасны агуулгыг ойлгох хэрэгтэй юм
Дараа нь сурагч хоёр веб хуудасны мэдээллийг нэгтгэх хэрэгтэй болно. Төгсгөлд нь сурагч бичвэрүүдийг ямар зорилгоор ашиглаж хэрхэн танилцуулах талаар эргэцүүлэн ёстой.

Галапагос 2/7

Танин мэдэхүйн үйл явц	Чанар, найдвартай байдлыг үнэлэх
Даалгаврын төрөл	Багц олон сонголт
Даалгаврын эх сурвалжийн шаардлага	Олон

- **Бүтэн оноо:** Анхаар бүгдийг зөв хийсэн тохиолдолд л өгнө.

Зөв хариу: үгүй, үгүй, тийм, тийм

Оноогүй: Бусад тохиолдолд

- **Тайлбар**
Энэ хэсгийн сүүлийн даалгавар нь сурагч арлууд болон Галапагосын байгаль хамгаалах нийгэмлэгийн талаар илүү ихийг олж мэдэх зорилготой. Ирээдүйн уншигчдад мэдээллийг илүү найдвартай байдлаар хүргэхийн тулд вебсайтын агуулгыг хэрхэн сайжруулах талаар авч үзэх ёстой болно. Эх сурвалжийг юу илүү найдвартай болгодог талаарх мэдлэгт тулгуурлана.